

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР

2025 оны 12 дугаар сарын 08

Улаанбаатар хот

Д/д	Шийдвэрийн нэр, огноо	Зүйл, заалтын дугаар	Зүйл, заалтын агуулга	Хэрэгжилтийн тайлан	Хэрэгжилт (Хэрэгжсэн/Хэрэгжээгүй/ХБ)	Хяналтаас хасах үндэслэл
166	2022 оны 12 дугаар сарын 12-ны өдөр 61 дүгээр тэмдэглэл 2022-12-14 Дугаар 2022_61	300	XIX.1. . “Соёлын төв өргөө”-ний ашиглалтын нөхцөл байдлын талаар Соёлын сайд Ч.Номин Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан “Соёлын төв өргөө”-ний байрны өмчлөлийн асуудлыг судалж эрх бүхий байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр саналаа танилцуулахыг Соёлын сайд Ч.Номин, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгав.	НИХТ-ын 2025 оны Дугаар 25/26 тогтоолоор Нийслэлийн Соёлын төв өргөө төсөвт үйлдвэрийн газрыг өөрчлөн байгуулж ОНӨААТҮГ хэлбэрт шилжүүлэн дүрмийг шинэчлэн баталсан. НИХТ-ын 2025 оны Дугаар 25/27 тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/796 дугаар захирамжаар Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын баланст бүртгэлтэй нийт 9.5 тэрбум төгрөгийн анхны өртөг бүхий барилгыг Нийслэлийн Соёлын төв өргөө ОНӨААТҮГ-ын баланст шилжүүлсэн.	Хэрэгжсэн	Нийслэлийн Соёлын төв өргөө ОНӨААТҮГ-ын баланст шилжүүлсэн

170	2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр 4 дүгээр тэмдэглэл 2023-01-18 Дугаар 2023_4	305	VIII.2.3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд орон нутгийн өмчит байгууллагаас татан төвлөрүүлсэн автомашиныг цаашид зайлшгүй шаардлагатай байгаа орон нутгийн өмчит хуулийн этгээдэд шилжүүлэх, худалдах, актлах ажлыг зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны болон орон нутгийн өмчит 64 хуулийн этгээдийн 166 тээврийн хэрэгслийг татан төвлөрүүлэн нийслэлийн Засаг даргын захирамжаар шинээр тээврийн хэрэгсэл худалдан авах хүсэлт ирүүлсэн байгууллагад балансаас баланст шилжүүлэн, ашиглалтын шаардлага хангахгүй тээврийн хэрэгслийг нээлттэй дуудлага худалдаа болон хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулсан. Үүнд: - 2022 оны 867 дугаар захиражаар 1 тээврийн хэрэгслийг Нийслэлийн Шүүхийн шийдвэрийн гүйцэтгэх газарт шилжүүлсэн, - 20022 оны А/913 дугаар захирамжаар 1 тээврийн хэрэгслийг БГД-ийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохилцуулах салбар зөвлөлийн ажлын албанд шилжүүлсэн, - 2022 оны А/1279 дүгээр захирамжаар 2 тээврийн хэрэгслийг БГД-ийн Тохижилт УТҮГ, Багануур ус ААТҮГ-д шилжүүлсэн, - 2022 оны А/1454 дүгээр захирамжаар дуудлагын автомашины зориулалтаар 62 тээврийн хэрэгслийг Төр захиргааны авто бааз ОНӨТҮГ-д шилжүүлсэн, - 2022 оны А/1629 дүгээр захирамжаар 2 тээврийн хэрэгслийг Нийслэлийн Мал эмнэлэгийн газар, Багачууд хүнс ОНӨААТҮГ-т шилжүүлсэн, - 2024 он А/606 дугаар захирамжаар Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын баланст бүртгэлтэй 28 тээврийн хэрэгслийг данснаас хасч, 30 тээврийн хэрэгслийг дуудлага худалдаа, хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулсан. -2024 оны А/240, 304, 608 дугаар захирамжаар Нийслэлийн Төр захиргааны	Хэрэгжсэн
-----	---	-----	---	---	-----------

				авто бааз УТҮГ-ын балансаас 6 тээврийн хэрэгслийг Нийслэлийн Замын хөдөлгөөний удирдлагын төв ОНӨТҮГ, Нийслэлийн Зоонозын өвчин судлагын төвд, Зорчигч тээвэр 5 ОНӨААТҮГ-т тус тус шилжүүлсэн.		
	ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДУУЛАН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАСТ ОРОН НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2025-03-07 Дугаар 2025_03	486	1.7. 1.7. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглал, менежментийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнд хяналт тавих;	1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А-1/702 дугаар бүхий "орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой нийт хуулийн этгээдийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, судалгааны тоо баримтыг нэгтгэхэд шаардлагатай тоон мэдээлэл, танилцуулга ирүүлэх" албан бичгийн дагуу нийслэлийн 106 хуулийн этгээдийн 2023, 2024 оны санхүүгийн тайлан, төсөвт төвлөрүүлсэн дүн, аудитын дүгнэлт, Төлөөлөн удирдах зөвлөл, Удирдах зөвлөлтэй холбоотой болон хүний нөөц, хөрөнгө оруулалтын судалгааг нэгтгэн албан бичгээр хүргүүлсэн. 2. Нийслэлийн өмчит 18 аж ахуй тооцоот үйлдвэрийн газрууд 2024 оны төсвийн гүйцэтгэлээр нийт орлого 555,551.9 сая төгрөг, нийт зардал 552,326.6 сая төгрөг, нийт 3,225.9 сая төгрөгийн ашигтай ажиллаж, 2024 оны батлагдсан зорилтоос орлого 45,062.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, зардлыг 4,982.5 сая төгрөгөөр хэмнэн ажилласан байна. Орон нутгийн өмчит аж ахуй тооцоот 19 үйлдвэрийн газруудын 2025 оны эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшний төслийг боловсруулан, Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/921 дүгээр захирамжаар нийт 19 ОНӨААТГ-ын 2025 оны зорилтыг нийт орлого 725,041.4 сая төгрөг, нийт	Хэрэгжсэн	

				зардал 794,567.0 сая төгрөг, ашиг алдагдал 25,845.9 сая төгрөг, хөрөнгө оруулалтын зардлыг 35,554.0 сая төгрөгөөр баталсан. 2. НИТХ-ын 2025 оны 25/18, 25/33, 25/108, 25/118, 25/130 дугаар тогтоолоор нийслэлийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн УЗ болон ТУЗ-ийн гишүүнээс албан тушаалаас чөлөөлөгдсөн, шилжсэн болон өөрийн хүсэлтийг үндэслэн 33 байгууллагын 60 гишүүнийг чөлөөлүүлж, 125 гишүүнийг шинээр томилсон. 3.Орон нутгийн өмчийг удирдах, орон нутгийн өмчийн газрын албан хаагчдыг чадавхжуулах зорилгоор 2024, 2025 онд орон нутгийн өмчит, орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага, НӨХГ-ын албан хаагчдыг компанийн засаглалын сургалтад хамруулсан. 2025.12.08-ны өдрийн байдлаар НӨХГ-ын 14 албан хаагч “Компанийн засаглалын гэрчилгээ”-тэй байна.		
--	--	--	--	---	--	--

ДАРГА  В.ОЮУМАА

ХЯНАСАН: ЗУХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН  Т. ОЮУНТУУЛ

НЭГТГЭСЭН: ЗУХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН  М.ЭНХБАЯР

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Нийслэлийн өмчийн харилцааны газар

2025 оны 11дүгээр сарын 25

Улаанбаатар хот

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Өөрийн үнэлгээ	Үнэлгээний тайлбар
ЗГ-ын албан даалгавар							
1	1	Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай 2025-06-18 Дугаар 2025_01	1.2.. Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг ханган, салбарын удирдлагын манлайллыг мэргэжлийн түвшинд хариуцлагатай хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж ажиллах;	Монгол Улсын Засгийн газрын 2024.10.02-ны өдрийн 109 дүгээр тогтоолоор "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ" шинэчлэн баталж байгууллагын Ёс зүйн дэд хороо албан хаагчдад мэдээлэл хүргэн, танхимын сургалтыг зохион байгуулсан. Нийт албан хаагчдад Засгийн газрын тогтоол, сургалтын материалыг ERP систем НӨХГ-ын бүлэг, байгууллагын албан ёсны цахим хуудсанд байршуулсан.		Хэрэгжсэн	
	2		1.3.. Яам, харьяа байгууллага, салбарын хэмжээнд сахилга, хариуцлагыг өндөржүүлж, бүх шатанд төсвийн хэмнэлтийн горимыг сахин, үр ашиггүй зардлыг танах, төрийн байгууллагын бүтэц, чиг үүргийн давхардлыг арилгаж, орон тоог үе шаттай цөөлөх;	Орон нутгийн төсвөөс 2,443.5 сая төгрөгийн санхүүжилт орж 1,600.3 сая төгрөгийг үр ашигтай зарцуулж ажилласан. Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/980 дүгээр захирамж, Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2024 оны Б/80 дугаар тушаалаар байгууллагын бүтэц, орон тоог шинэчлэн баталсантай холбоотойгоор албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, албан тушаалд тавигдах чиг үүргийн давхардлыг арилгасан байна.		Хэрэгжсэн	
	9		2.2.. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн дагуу нууцад хамааруулах шаардлагагүй мэдээллийг зохих журмын дагуу ил болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Тус газрын Төрийн албаны нууцын тухай хуулийн дагуу албан нууцад хамааруулах мэдээллийг зохих журмын дагуу албан бичгээр холбогдох байгууллагад хүргүүлж шаардлагагүй ил болгох материал байхгүй байна.		Хэрэгжсэн	
	12		2.5.. Төрийн албан хаагчийг хууль бусаар томилж, чөлөөлөх,	Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан үндэслэл, шаардлагыг баримтлан ажиллаж		Хэрэгжсэн	

			аливаа хэлбэрээр дарамт, шахалт үзүүлэхгүй байх;	байгаа бөгөөд 2025 оны 08 дугаар сарын байдлаар зөрчилтэй томилогдсон 4 албан хаагчийн томилгооны зөрчлийг бүрэн арилган ажиллаж байна.			
2	16	Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах тухай албан даалгавар 2025-07-08 Дугаар 2025_03	1.1. Улс төрөөс ангид, чадахуйн зарчимд суурилсан хүртээмжтэй, шуурхай, хариуцлагатай төрийн үйлчилгээг хүргэх, хүнд суртал, шат дамжлагыг бууруулах үр дүнтэй ажлыг зохион байгуулан, ажлын бүтээмжийг нэмэгдүүлж, цахим шилжилтийг эрчимжүүлэх	Цахим монгол үндэсний хөтөлбөр, Алсын хараа 2050 хөгжлийн бодлогын төлөвлөлтийн хүрээнд Төрийн Өмчийн бодлого зохицуулалтын газраас цахим системийг бий болгон "Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн цахим систем"-ийг нэвтрүүлэх сургалтыг Улаанбаатар хотод 2025.10.23-ны өдрөөс 2025.10.30-ны өдрийн хооронд амжилттай зохион байгууллаа. Энэхүү цахим системд дараах мэдээлэл орно Үүнд: - Төрийн болон оройн нутгийн өмчийн эл хөрөнгийн бүртгэл, тооллого, хөдөлгөөн - Хөрөнгө оруулалт - Компанийн засаглал - Хяналт шалгалт, холбогдох тогтоол шийдвэр зэрэг мэдээлэл Цахим шилжилтийн хүрээнд: - Системийг ард иргэдэд нээлттэй үе шаттай нээж, төрийн өмчийн мэдээллийг иргэдэд нээлттэй, ил тод болгоно - Төрийн үйлчилгээний мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшил, инновац нэвтрүүлэх замаар бүтээмж, үр ашгийг дээшлүүлэх, - Өмчийн талаарх мэдээллийг цаг хугацааны алдагдалгүйгээр нэгдсэн мэдээллийн сангаас шуурхай олж авах, - Өгөгдлийн санд цуглуулсан мэдээллийг ашиглан дараагийн шийдвэр гаргалтад ашиглах боломжийг бүрдүүлэх, - Үл хөдлөх хөрөнгө, газар гэх мэт үнэ цэнтэй хөрөнгүүдийг газрын зураг дээр тэмдэглэх, - Өмчийн харилцаатай холбоотой бүх процессыг тус программ хангамжаар		Хэрэгжсэн	

			дамжуулан хийдэг болох зэрэг олон давуу тал бий болох юм.			
17		1.2. харьяа байгууллага, хуулийн этгээдийн хэмжээнд сахилга, хариуцлагыг чангатгаж, төсвийн үр ашиггүй зардлыг танан, хэмнэлтийн горимыг чанд мөрдөх, бүтэц, чиг үүргийн давхардлыг арилган, орон тоог үе шаттай цөөлөх	Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/980 дүгээр захирамж, Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2024 оны Б/80 дугаар тушаалаар байгууллагын бүтэц, орон тоог шинэчлэн баталсантай холбоотойгоор албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, албан тушаалд тавигдах чиг үүргийн давхардал, төсвийн үр ашиггүй зардлыг танан, арилгасан байна. Байгууллагын бүтэц, орон тоо нийт 63 албан хаагч байхаас 2025 оны 8 сарын байдлаар одоо ажиллаж байгаа 41, хүүхэд асрах чөлөөтэй 6, нийт 47 албан хаагч ба 74.6 хувийн албан хаагч ажиллаж 15.4 хувийн сул орон тоотойгоор ажиллаж байна. НЗДТГ-т 2025.11.20-ны өдөр бүтэц, орон тоог 9 хувиар бууруулж, 58 орон тоотой байхаар талаар саналыг ERP системээр хүргүүлсэн.		Хэрэгжсэн	
19		1.4. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг ханган, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх	Монгол Улсын Засгийн газрын 2024.10.02-ны өдрийн 109 дүгээр тогтоолоор “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ” шинэчлэн баталж байгууллагын Ёс зүйн дэд хороо албан хаагчдад мэдээлэл хүргэн, танхимын сургалтыг зохион байгуулсан. Нийт албан хаагчдад Засгийн газрын тогтоол, хавсралт, сургалтын материалыг ERP систем НӨХГ-ын бүлэг, байгууллагын албан ёсны цахим хуудсанд байршуулсан		Хэрэгжсэн	
20		1.5. Төрийн албан хаагчийг хууль бусаар томилж, чөлөөлөх аливаа хэлбэрээр дарамт, шахалт үзүүлэхгүй байх	Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан үндэслэл, шаардлагыг баримтлан ажиллаж байгаа бөгөөд 2025 оны 08 дугаар сарын байдлаар зөрчилтэй томилогдсон 4 албан хаагчийн томилгооны зөрчлийг бүрэн арилган ажиллаж байна.		Хэрэгжсэн	

	21	1.6. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад томилолтыг хязгаарлаж, төсвийн хөрөнгөөр олон нийтийн арга хэмжээг зохион байгуулахгүй байх талаар харьяа байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг өгч, үр дүнг тооцож ажиллах	Нийслэлийн өмчийн харилцааны газраас 2025 он гарснаас хойш Төрийн хэмнэлтийг тухай хуулийн дагуу, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад томилолт, төсвийн хөрөнгөөр олон нийтийн арга хэмжээ, төсвийн зардал зарцуулагдаагүй байна.		Хэрэгжсэн	
	22	2.1. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн дагуу албаны нууцад хамааруулах шаардлагагүй мэдээллийг зохих журмын дагуу ил болгох	Нийслэлийн өмчийн харилцааны газрын Төрийн албаны нууцын тухай хуулийн дагуу албан нууцад хамааруулах мэдээллийг зохих журмын дагуу албан бичгээр холбогдох байгууллагад хүргүүлж шаардлагагүй ил болгох материал байхгүй байна.		Хэрэгжсэн	
	23	2.2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгах үүргийн биелэлтэд харьяа байгууллага, хуулийн этгээдийн хэмжээнд тогтмол хяналт тавьж, зөрчсөн этгээдэд хариуцлага тооцож ажиллах	Нээлттэй мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хүрээнд байгууллагын дотоодын болон гадагшаа чиглэсэн мэдээ мэдээлэл, АТГ-ын мэдээ мэдээлэл, НЗДТГ-ын Улаанбаатар мэдээ болон https://www.ulaanbaatar.mn/home сайтын мэдээ мэдээлэл, бусад нийслэлийн харьяа агентлаг, ННЗБ-ын онцлох мэдээ мэдээллийг сайтад болон пэйж хуудсаараа өдөр бүр нийтэлж, хуваалцаж байна. Үүнд: - Байгууллагын цахим хуудас https://www.umch.ub.gov.mn/ сайм, - фейсбүүк пэйж хуудас https://www.facebook.com/umch.ub.gov.mn, - Инстаграмм хуудас https://www.instagram.com/umch_ub_official/#, - Юутүб хуудас https://www.youtube.com/@%D0%9D%D3%A8%D0%A5%D0%93. 2025 онд цахим хуудас, олон нийтийн сүлжээний фейсбүүк пэйж, инстаграм, юубүд хуудсаар дамжуулан байгууллагатай холбоотой мэдээ мэдээлэл-76 , түрээслэгч		Хэрэгжсэн	

			сонгон шалгаруулах зар-113, өмчийн дуудлага худалдааны зар-13, түүнчлэн Нийслэл, ННЗБ-ын онцлох мэдээ мэдээлэл буюу цаг үеийн мэдээ мэдээлэл- 580 гаруй нийтлэгдлээ. Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлж буй Шил ажиллагаа ажиллагааны хүрээнд байгууллагын 2 дугаар улирлын тайланг 96,67% ; 3-р улирлын тайланг 84% үнэлгээтэй дүгнүүлж http://www.shilen.gov.mn/index сайт дээр нээлттэй байршуулав.			
24		2.3. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллаж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, хүнд суртал, шударга бус байдалтай тууштай тэмцэх, таслан зогсоох, албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглахгүй байх, бүх шатанд Ёс зүйн дэд хороодыг байгуулж үйл ажиллагааг нь идэвхжүүлэх	I.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/76 дугаар тушаалаар Ёс зүйн дэд хороог 5 гишүүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулан дараах сургалтыг зохион байгуулсан. Үүнд: - Ёс зүйн дэд хорооны ажиллах журам, гомдол гаргах үндэслэлийн талаар танилцуулга сургалт, - Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн талаар танилцуулга сургалт - Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ сэдэвт сургалтуудыг тус тус зохион байгуулж, нийт албан хаагчдыг хамруулсан. II. Авлигатай тэмцэх газрын хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсээс 2025.01.15-ны өдөр зохион байгуулсан “Мэдүүлэг гаргагчдад зориулсан сургалт”-д 7 албан хаагчийг, 2025.01.06-ны өдөр зохион байгуулсан “Мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах, эрх бүхий албан тушаалтнуудын сургалт”-д 1 албан хаагчийг тус тус хамруулсан. Мөн Авлигатай тэмцэх газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран 2025 оны 05 дугаар сарын 26, 2025		Хэрэгжсэн	

3	32		оны 06 дугаар сарын 01-ний өдрүүдэд “Хүүхдийн шударга байдлыг нэмэгдүүлэх” ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр 2 удаагийн арга хэмжээг зохион байгуулсан.			
		4.4. Ажилтны мэдлэг, боловсролын түвшин мэргэжлийн ур чадварыг хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлэхэд байнга анхаарч, давтан сургах, мэргэшүүлэх, шинэ мэргэжил эзэмшүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	Байгууллагын батлагдсан сургалтын төлөвлөгөөний дагуу Удирдлагын академийн ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 4 албан хаагч, Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан сургалтад 13 албан хаагч, бусад байгууллагаас зохион байгуулсан 14 удаагийн сургалтад давхардсан тоогоор 83 албан хаагчдыг хамруулсан.		Хэрэгжсэн	
	35	ЗАСГИЙН ГАЗРААС ШУУРХАЙ АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2025-07-25 Дугаар 2025_04	1.2.. төрийн албан тушаалын чиг үүргийн давхардлыг арилгах, удирдах албан тушаалтны тоог бууруулах арга хэмжээ авч, байгууллагын орон тоог нэмэгдүүлэхтэй холбоотой аливаа шийдвэр гаргахгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоо болон сул орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүй байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад;	Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/980 дугаар захирамж, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны Б/80 дугаар тушаалаар байгууллагын бүтэц, орон тоог шинэчлэн баталж, чиг үүргийн давхардлыг арилгасан. НЗДТГ-т 2025.11.20-ны өдөр бүтэц, орон тоог 9 хувиар бууруулж, 58 орон тоотой байхаар талаар саналыг ERP системээр хүргүүлсэн. Байгууллагын чиг үүрэг, стратеги төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндэслэн ажлын байрны шинжилгээ боловсруулж байна.		Хэрэгжсэн
	36		1.3.. иргэддээ чин шударгаар үйлчилдэг, ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлэх зорилгод нийцүүлэн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг чанд мөрдүүлэх, хуулийг сурталчлан таниулах үйл ажиллагааг зохион байгуулж	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Ёс зүйн дэд хорооноос 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр албан хаагчдад ёс зүйн талаарх мэдээлэл хүргэх зорилгоор “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ” сэдэвт танхимын сургалт зохион байгуулсан		Хэрэгжсэн

		ажиллахыг төрийн бүх шатны удирдлагад;				
	37	1.4.. төрийн байгууллагын ёс зүйн дэд хороог 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор гүйцээн байгуулж ажиллуулахыг бүх шатны төрийн байгууллагын удирдлагад;	Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/76 дугаар тушаалаар “Ёс зүйн дэд хороо шинэчлэн батлах тухай” байгуулсан. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хэвийн, тасралтгүй явагдаж байна.		Хэрэгжсэн	
	38	1.7.. Төрийн албаны тухай хуульд зааснаас бусад үндэслэлээр төрийн албан хаагчдыг төрийн албанаас чөлөөлөхгүй, халахгүй, хуулиар чиг үүрэгт нь өөрчлөлт ороогүй тохиолдолд төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулахгүй байх, төрийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц өөрчлөгдсөн боловч албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг нь хэвээр хадгалагдан үлдсэн төрийн жинхэнэ албан хаагчдыг чөлөөлөх, халах, албан тушаал бууруулах, шилжүүлэх шийдвэр гаргахгүй байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт;	Тус газраас 2025 онд Төрийн албаны тухай хуульд зааснаас бусад үндэслэлээр албан хаагчдыг чөлөөлөх, халах, албан тушаал бууруулах шийдвэр гаргаагүй болно.		Хэрэгжсэн	

	39	1.8.. ажлын байрны нээлттэй мэдээлэлд үндэслэн төрийн албан хаагчдыг хувийн хэвшилд шилжүүлэн ажиллуулах санал боловсруулж, цалин хөлс, нийгмийн баталгааны талаарх мэдээллийг төрийн албан хаагчдад хүргэх уулзалт, арга хэмжээг Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим болон холбогдох бусад байгууллагатай хамтран зохион байгуулахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт	Албан хаагчдад ажлын байрны нээлттэй мэдээлэл хүргэх зорилгоор www.zangia.mn , worki.mn болон бусад нээлттэй ажлын байрны талаарх мэдээллийг хүргэж ажилласан.		Хэрэгжсэн	
--	----	--	---	--	-----------	--

ДАРГА *В. Оюумаа* В.ОЮУМАА

ХЯНАСАН: ЗУХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Т.Оюунтуул

Т.ОЮУНТУУЛ

НЭГТГЭСЭН: ЗУХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН

М. Энхбаяр

М.ЭНХБАЯР